

СУДАЛГАА

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 4-Р ХОРООНЫ 30-60 НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙГ ДҮГНЭСЭН НЬ

Ц.Энхтүвшин¹, Д.Удаанжаргал², Б.Мөнхцэцэг³, Б. Туяажаргал⁴¹Угтахуй ӨЭМТ²Учралтбаяр ӨЭМТ³Энхжихмандарваа ӨЭМТ⁴АШУУИС, АУС, Өрхийн анагаах ухааны тэнхим
Botuugii.0726@gmail.com**Түлхүүр:** Эрт илрүүлэг, эмэгтэйчүүд

Судалгааны үндэслэл: Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээллээр 2020 онд 19,2 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9,9 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. Монгол улс дэлхийд хорт хавдрын нас баралтаар тэргүүлж байна. Монгол улсад 2021 онд 5981 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдэж, үүний дотор умайн хүзүүний хорт хавдар 5,2 хувийг эзэлж байгаа бөгөөд умайн хүзүүний хорт хавдрын түвшин өвчлөлийн түвшин дунджаар 100,000 эмэгтэйд 19,1 тохиолдол, нас баралт 100,000 эмэгтэйд 9,6 тохиолдол байгаа нь бүс нутаг дотроо өндөр үзүүлэлттэй байна.¹

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар зонхилон тохиолдож байгаа хавдрын хоёрдугаарт умайн хүзүүний хорт хавдар орж байна. Умайн хүзүүний хорт хавдрын гол шалтгаан нь хүний папиллома вирусийн (HPV) омгууд бүхий архаг халдвар бөгөөд энэ нь бэлгийн замын халдварт өвчнөөс голчлон үүсдэг байна.²

Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 400 орчим эмэгтэй умайн хүзүүний хорт хавдараар оношлогдож, 150 орчим нь нас барж байна.³ 2021 оны байдлаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг шинжилгээнд 68163 эмэгтэй хамрагдсан байна. Энэ нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 28,6 хувийг эзэлж байна.⁴ Үүнээс харахад умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамрагдах хувь бага байна. Тиймээс эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хавдрын талаар мэдлэг олгож эрт илрүүлэгт хамрагдах хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Судалгааны зорилго: Баянгол дүүргийн 4-р хорооны эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамруулж дүгнэх.


Материал, арга зүй: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийсэн. Баянгол дүүргийн 4-р хорооны 30-60 насны нийт 100 эмэгтэйчүүдийг санамсаргүй түүврээр сонгон авч, умайн хүзүүний ПАП шинжилгээ хийж, статистик боловсруулалтыг STATA13 программ ашигласан.

Үр дүн:

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн насны дундаж

	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн их	Хамгийн бага
Нас	43.06	8.4	60	30


Нийт судалгаанд 100 эмэгтэй хамрагдсанаас насны дундаж нь 43(±8.4) байв. Насны далайц нь 31 байв /Хүснэгт 1/.



Зураг 1. Эмэгтэйчүүдийн гэрлэлтийн байдал, хувиар

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 79% нь албан ёсоор гэр бүлээ батлуулсан бол, 20% нь гэр бүлээ батлуулаагүй, 1%

нь огт гэрлээгүй эмэгтэйчүүд байсан ба умайн хүзүүний хавдраар өвдөх эрсдэл өндөр байж болно. /Зураг 2/.



Зураг 2. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлт, төрөлтийн байдал, тоогоор


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлтийн тоо нь 353 (давхардсан байдлаар) байсан бол үүнээс төрөлт нь 237 (67.1%), үр хөндөлт 88 (24.9%),

зулбалт 28 (7.9%) байв /Зураг 2/. Үр хөндөлт, зулбалт их байгаа нь умайн хүзүүний хавдраар өвдөх эрсдэл байгааг харуулж байна.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлт, жирэмслэлт шийдсэн байдлын үзүүлэлт

Төрөл	Дундаж үзүүлэлт	Стандарт хазайлт	Мах утга
Жирэмслэлт	3.53	1.8	9
Төрөлтийн	2.37	1.1	6
Үр хөндөлтийн	0.9	1.1	7
Зулбалт	0.2	0.6	4


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дундаж жирэмслэлт 3,5(±1.8) төрөлт нь 2.3(±1.1), үр хөндөлт 0.9(±1.1), зулбалт 0.2(±0.6) байна /Хүснэгт 2/.



Зураг 3. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс сэргийлэх арга

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 82% нь жирэмслэлтээс хамгаалах ямар нэгэн арга хэрэглэдэггүй байна. 18% нь жирэмслэлтээс хамгаалах


аргыг хэрэглэдэг байна /Зураг 5/. Жирэмслэлтээс сэргийлэх аргын талаарх мэдлэг муу байх нь хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдэг.



Зураг 4. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн цэвэршсэн эсэх


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 17% нь цэвэршсэн байна. Цэвэршсэн эмэгтэйчүүдийн хамгийн залуу нь 34 настай байна /Зураг 6/. Үрэвсэл,

жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэггүй, жирэмсний төгсгөл шийдэж буй байдал зэрэг нь цэвэршилт эрт явагдах нөхцлийг үүсгэнэ.



Зураг 5. Эсийн шинжилгээнд хамрагдсан байдал

Нийт эмэгтэйчүүдийн 30 хувь нь анх удаа, 70 хувь нь 2,3 болон түүнээс дээш удаа хамрагдаж байна.



Зураг 6. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс илэрсэн өвчлөл

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 62%-д үтрээний үрэвсэл илэрч байгаа нь эмэгтэйчүүд бэлгийн эрүүл мэнддээ төдийлэн сайн анхаардаггүйг

харуулж байна. Үтрээний үрэвсэлтэй эмэгтэйчүүдийн 71%-д коккобацилл илэрсэн байна /Зураг 6/.



Зураг 7. Умайн хүзүүний эсийн шинжилгээ дүгнэлт

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн шинжилгээний дүгнэлт

	1 удаа	2 удаа	3 удаа	4 удаа	Р утга
Хэвийн	24	16	4	36	0,001
Хэвийн бус	20				0,002

Хэлцэмж

Хүний папиллома вирус, бэлгийн хавьталд эрт орох, бэлгийн олон хавьтагчтай байх, бэлгийн замаар дамжих халдвар мөн олон удаа үр хөндүүлсэн, эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, хэт хожуу цэвэршилт, жирэмснээс хамгаалах дааврын бэлдмэл удаан хугацаагаар хэрэглэдэг, тамхи татдаг эмэгтэйчүүд УХХХ-аар өвчлөх эрсдэл өндөр байдаг. Иймээс 30-аас дээш насанд 3 жил тутам тогтмол эсийн шинжилгээ өгснөөр умайн хүзүүний хорт хавдрын урьдал эмгэг болон умайн хүзүүний хорт хавдар, нас баралтаас бүрэн урьдчилан сэргийлэх боломжтой юм. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт үе шатанд оношилвол бүрэн эдгэрэх боломжтой өвчин юм. АНУ-д 1950-1980 оны хооронд умайн хүзүүний эсийн шинжилгээ буюу эрт илрүүлэгт хамрагдсанаар умайн хүзүүний шалтгаант нас баралт, өвчлөлийг 70% бууруулсан байна. Австрали улс 70 жилийн хугацаанд умайн хүзүүний

эсийн шинжилгээ өгч эрт илрүүлэгт хамрагдсанаар нас баралт өвчлөлийг бүрэн бууруулж байна. ДЭМБ-ын судалгаагаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн эсийн шинжилгээг өгснөөр дэлхий дахинд сүүлийн 30 жилийн хугацаанд энэ төрлийн шалтгаант нас баралтыг 50% бууруулсан гэж үзэж байна. Умайн хүзүүний эрт илрүүлэгт хугацаандаа орох нь хавдрын өвчлөлийг бууруулж байна.

Дүгнэлт

Умайн хүзүүний эсийн шинжилгээний хариу эрүүл буюу хавдрын урьтал илрээгүй байгаа нь хамрагдалт сайн байгааг харуулж байна.

Ёс зүйн зөвшөөрөл: Энэхүү судалгааг Био-Анагаахын ёс зүйн зарчмуудыг баримтлан, ёс зүйн асуудал хөндөгдөөгүй. Судалгаанд оролцогчдод судалгааны зорилго, арга аргачлалыг танилцуулан, мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглахыг тайлбарлаж,

таниулсан зөвшөөрсөн хуудас бөглүүлэн судалгааны ажлыг явуулсан. Судалгаанд оролцогчдын хувийн нууцыг чандлан хадгалж, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэхэд хувь хүний нэрийг, хувийн мэдээлэл дурдаагүй болно.

Талархал: БГД 4-р хороо Угтахуй өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, нөхөн үржихүй хариуцсан эмч, ПАП шинжилгээг авсан эмнэлгийн мэргэжилтнүүд болон судалгааг бичихэд зөвлөгөө өгсөн АШУҮИС-Өрхийн анагаах ухаан судлалын тэнхимийн багш нартаа баярлалаа.

Ном зүй

1. Б.Болорчимэг “Эмэгтэйчүүдийн өвчин судлал” 2024 он
2. Б.Жав, Ж. Лхагвасүрэн “Эмэгтэйчүүд судлал” 2018 он
3. Угтахуй ӨЭМТ-ийн 16-49 насны эмэгтэйчүүдийн өвчний бүртгэл судалгаа 2023 он
4. “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар” 2020 он
5. Цэвэршилтийн үеийн оношилгоо, даавар нөхөх эмчилгээний заавар 2016 он
6. Эрүүл мэндийн хөгжлийн төв статистик мэдээ 2022 он
7. “Эмэгтэйчүүдийн эс судлал” гарын авлага 2017 он
8. Xiaoxian Li et al. Papilloma diagnosed on core biopsies has a low upgrade rate. Clin Imaging. 2020 Mar
9. Jagmohan,P pool,putti.TC. Papillary lesions of the breast imaging findings and diagnostic challenges
10. Swapp,RE Glazebrook, KN Jones,KN. Management of benign intraductal solitary papilloma diagnosed on core needle biopsy
11. Shiino. S. Tsuda, H.Yoshida. Intraductal papillomas on core biopsy can be upgraded to malignancy on subsequent excisional biopsy regardless of the presense of atypical features
12. Ault, K.A. Effect of prophylactic human papillomavirus L1 virus-like-particle vaccine on risk of cervical intraepithelial neoplasia grade 2, grade 3, and adenocarcinoma in situ: a combined analysis of four randomized clinical trials
13. American Society of Clinical Oncology. Risk factors for vaginal cancer
14. moh.gov.mn
15. <https://1212.mn/>

ABSTRACT

THE RESULTS OF CERVICAL CANCER EARLY SCREENING IN WOMEN AGED BETWEEN 30-60 YEARS, RESIDENT AT THE 4TH KHOROO OF BAYANGOL DISTRICT

*Enkhtuvshin Ts¹, Udaanjargal D², Munkhtsetseg B³, Tuyajargal B⁴**¹Ugtakhui Family Health Center**²Uchraltbayar Family Health Center**³Enkhjihmandarvaa Family Health Center**⁴Department of Family Medicine, School of Medicine, MNUMS**Pti1220327@pt.mnum.edu.mn***Keywords:** Screening, woman

Introduction: According to statistics from the World Health Organization, more than 19.2 million population were diagnosed with cancer in 2020, and 9.9 million population died from cancer. Furthermore, Mongolia leads the world in terms of cancer mortality. In Mongolia, 5981 new cancer incidences were registered in 2021, including cervical cancer, which accounts for 5.2 percent. The average incidence rate of cervical cancer is 19.1 cases per 100,000 females, and the mortality rate is 9.6 cases per 100,000 females, which is high in the region. As of 2021, 68,163 females have undergone early screening of cervical cancer. This represents 28.6 percent of eligible women. It can be seen that the rate of early screening of cervical cancer is low. Thus, it is essential to increase the percentage of early screening by providing knowledge regarding cervical cancer in women.

Purpose: The study is aimed to screen the women for cervical cancer and make a conclusion among women, living in the 4th khoroo of Bayangol district.

Material and method: The study was conducted using an analytical cross sectional design. A total of 100 women aged between 30 and 60 years of the 4th khoroo of Bayangol District were randomly chosen, cervical Pap tests were performed, and STATA13 software was used for statistical analysis.

Result:

- Out of a total of 100 females participating in the study, 79% were married, 24.9% had an abortion, 82% do not use contraception, and 17% were post-menopausal.
- 80% of the women who participated in the study had a healthy cervical cytology or no tumor cells, while 62% had vaginitis (coccobacillus 71%).

Conclusion: Cervical pap smear results that are healthy or not precancerous indicate good coverage.